



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (605)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Журам батлах тухай*
- *Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны наймдугаар сарын 27 № 32 (605)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

443.	Дашийн Бямбасүрэнг "Чингис хаан" одонгоор шагнах тухай	Дугаар 39	727
444.	Зарим хүнийг одон медалиар шагнах тухай	Дугаар 40	727

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

445.	Журам батлах тухай	Дугаар 89	728
446.	Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм батлах тухай	Дугаар 90	732
447.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 93	733
448.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 98	733

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

449.	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 03	734
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

ДАШИЙН БЯМБАСҮРЭНГ "ЧИНГИС ХААН" ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, эх орондоо хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулахад оруулсан жинтэй хувь нэмэр, түүхэн гавъяаг нь

үнэлж Дашийн Бямбасүрэнг "Чингис хаан" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, эрчим хүч, батлан хамгаалах, цагдаа, хэвлэл, мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус

байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

1. Гэндэнгийн Бямбажал - "Ардын эрх" сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга

2. Маамуугийн Цэрэнбат - "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн Баянзүрх салбарын дарга

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Гомбосүрэнгийн Ёндонсамбуу - "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-ын дэд ерөнхийлөгч

2. Өлзий-Очирын Мангалбазар - Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентген оношлогооны их эмч



ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Лувсан-Очирын Батболд - ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, дэд хурандаа
2. Раднаагийн Батдэлгэр - БХИС-ийн

Батлан хамгаалахын удирдлагын академийн багш, хурандаа

3. Ядамдоржийн Пүрэвдорж - Хилийн цэргийн дээд сургуулийн дэд захирал, хошууч генерал

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Чойжамцын Баттуяа - Орхон аймгийн "Эрдэнэт-Булганы цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн гүйцэтгэх захирал
2. Болзоогийн Даваахүү - Үндсэний статистикийн газрын хүн ам,нийгмийн статистикийн газрын ахлах шинжээч

3. Жанчивдоржийн Дэнсмаа - Архангай аймгийн Батцэнгэл сумын мал эмнэлгийн "Тахилгат нуурын овоо" ХЗАА-н нягтлан бодогч

4. Сэдгээгийн Цогтоо - Хөвсгөл аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах ажилтан

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Пандийн Буянхүү - ХХЕГ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын хэлтсийн дарга, хурандаа
2. Дамбийбалжирын Жаргалсайхан - ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын орлогч дарга, хурандаа

3. Бадамхандын Лувсан - Зэвсэгт хүчний барилгын цэргийн 017 дугаар ангийн жагсаал ангийн дарга, дэд хурандаа

4. Самдангийн Нармандах - Цагдаагийн академийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хошууч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Бямбажавын Баасанжав - Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нягтлан бодогч
2. Намдагийн Баянбулаг - Дархан-Уул аймгийн Орхон сумын өндөр настан, ахмад зөгийчин
3. Хүүхэнжавын Жаргалсайхан - Хилийн

цэргийн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа

4. Чимэдбазарын Найданжав - Архангай аймгийн "Хүмүүн" цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

5. Намсрайн Тунгалаг - УИХ-ын Тамгын газрын зөвлөх

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Мукариягийн Аюез - Хилийн цэргийн 0165 дугаар ангийн тасгийн дарга, дэд хурандаа
2. Батмөнхийн Мөнхсүх - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн хуягт танкийн техникийн засварын цехийн дарга, дэд хурандаа
3. Ганчулууны Оюун-Эрдэнэ - Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын бүжигчин, ахлах ахлагч
4. Чимэдгочоогийн Цогтжаргал - БХИС-Батлан хамгаалахын удирдлагын академийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга, дэд хурандаа

5. Дамдинбазарын Чулуунбат - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн дайчилгааны офицер, дэд хурандаа

6. Доржийн Энхбаяр - Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

7. Нямдавын Эрдэнэбаатар - Хилийн цэргийн 0168 дугаар ангийн уурын зуухны механикч, ахлах ахлагч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гаалийн болон бусад татавар төлөх баталгаа гаргах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 10

дугаар сарын 26-ны өдрийн 245 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2009 оны 89 дүгээр
тогтоолын хавсралт

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР ТӨЛӨХ БАТАЛГАА ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бараа, тээврийн хэрэгслийг гажлийн хилээр нэвтрүүлэхэд гаалийн татвар болон гаалийн байгууллагаас ногдуулж байгаа бусад татвар төлөх баталгаа гаргуулах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Татвар төлөх баталгааны хэлбэр

2.1. Мэдүүлэгч татвар төлөх баталгааг дараахь хэлбэрээр гаргана:

2.1.1. бараа, мөнгөн хөрөнгө барьцаалах;

2.1.2. банкны баталгаа гаргах;

2.1.3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан бусад хэлбэр (ТИР карней, АТА, СПД карней).

Гурав. Бараа, мөнгөн хөрөнгө барьцаалах

3.1. Гаалийн хилээр нэвтрүүлж байгаа энэ журмын 3.3-т зааснаас бусад барааг татварын барьцаанд авч болно.

3.2. Барааг барьцаанд авахад энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан загвар бүхий бараа барьцаалах гэрээ байгуулна.

3.3. Дараахь барааг барьцаанд авахыг хориглоно:

3.3.1. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тосн хязгаарлалт тогтоосон, хадгалалтын тусгай нөхцөл шаардсан бараа;

3.3.2. хүнсний бараа, эм, тариа;

3.3.3. мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, магадлан шинжилгээ хийлгэх бараа;

3.3.4. цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;

3.3.5. онцгой албан татвартай бараа;

3.3.6. үйлдвэрлэл, техникийн зориулалттай бараа;

3.3.7. борлуулалтын явцад төсвийн орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх, зах зээлд үнэ нь тогтворгүй бараа;

3.3.8. бүх төрлийн барилгын материал.

3.4. Мөнгөн хөрөнгө барьцаалахад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.3-т заасан хэмжээний мөнгөн хөрөнгийг гаалийн байгууллагын тусгай дансанд байршуулж болно.

3.5. Энэ журмын 3.2-т заасан гэрээ байгуулах мэдүүлэгч нь барьцааны барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр түр агуулахад хадгалуулна. Хадгалуулсан барааны чанар, тоо хэмжээ, бүрэн бүтэн байдлыг агуулах эзэмшигч, гарах зардлыг мэдүүлэгч хариуцна.

Дөрөв. Банкны баталгаа гаргах

4.1. Монгол банкны "Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл" болон Сангийн яам, гаалийн удирдах төв байгууллага, арилжааны банк хооронд "Арилжааны банкинд улсын төсвийн орлогын дансыг нээх болон түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ" хийсэн банкны байгууллагаас гаргасан "Банкны баталгаа"-г хүлээн зөвшөөрнө.

4.2. Банкны баталгаа нь энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан загвар бүхий байна.

4.3. Баталгаа гаргасан банкны байгууллага нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үүргийг гүйцэтгэнэ.

Тав. Олон улсын гэрээнд заасан баталгааны бусад хэлбэр

5.1. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан татварын баталгааны дараахь хэлбэрүүд байна:

5.1.1. Барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай ТИР конвенцийн дагуу гаргасан баталгаа/ТИР карней/;

5.1.2. Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенцийн дагуу гаргасан баталгаа/АТА, СПД карней/.

Зургаа. Бараа, мөнгөн хөрөнгө барьцаалах, банкны баталгааг хүлээн зөвшөөрөх, гаалийн бүрдүүлэлт хийх

6.1. Банкны баталгаа болон Бараа барьцаалах гэрээний хугацаа нь гаалийн бичиг баримтын бүрдүүлэлт хийсэн өдрөөс хойш 2 сар хүртэл хугацаанд хүчинтэй байна.

6.2. Барааг түр хугацаагаар оруулах горимоор байршуулсан барааг хугацаанд нь буцааж гаргасан тохиолдолд тусгай дансанд байгаа мөнгөн хөрөнгийн барьцааг буцаан олгоно. Барааг хугацаанд нь буцааж гаргаагүй тохиолдолд тусгай дансанд байгаа мөнгөн хөрөнгийн барьцааг үл маргах журмаар улсын төсвийн орлогод төвлөрүүлнэ.

6.3. Гаалийн байгууллагад өртэй, татварын барьцаанд бараа нь байгаа, банкны баталгааны хугацаа нь дуусаагүй аж ахуйн нэгж, байгууллагатай дахин бараа барьцаалах гэрээ байгуулах, банкны баталгаа гаргуулахыг хориглоно.

Долоо. Гаалийн байгууллагын үүрэг

7.1. Гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага нь банкны баталгааны хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө ногдуулсан татварын тооцоог баталгаа гаргасан банкинд хүргүүлж, татвар төлөхийг бичгээр мэдэгдэнэ.

7.2. Банкны баталгаа гаргасан гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй арилжааны банийг Монголбанкинд мэдэгдэж, баталгааг хангуулах арга хэмжээ авна.

7.3. Бараа барьцаалах гэрээний хугацаа дууссан барьцааны барааг улсын орлого болгох, зохих журмын дагуу борлуулах ажлыг гэрээ байгуулсан гаалийн байгууллага зохион байгуулж, орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ.

7.4. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар нэвтрүүлсэн барааг хугацаанд нь буцаан нэвтрүүлсэн тохиолдолд гаалийн байгууллагын тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан олгохдоо тухайн барааг оруулж ирэхэд болон гаргахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлэг, татвар тушаасан төлбөрийн баримт, мэдүүлэгчээс гаалийн байгууллагад бичгээр гаргасан хүсэлт, нэхэмжлэлийг үндэслэн дараахь байдлаар шийдвэрлэнэ:



7.4.1. тухайн байгууллага, иргэний Монгол Улсын нутаг дэвсгэрт байрших банкны харилцах дансанд ажлын 10 хоногийн дотор шилжүүлэх;

7.4.2. мэдүүлэгч хүсвэл тухайн болон дараагийн ачилтаар ирэх барааны татварт шилжүүлэн тооцох.

7.5. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг анх нэвтрүүлсэн гаалийн байгууллагаар буцаан гаргасан бол тухайн гаалийн байгууллага энэ журмын 7.4-т заасны дагуу татварын асуудлыг шийдвэрлэнэ. Гаалийн өөр боомтоор буцаан нэвтрүүлсэн тохиолдолд барьцаанд төлсөн хөрөнгийг

буцаан олгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

7.6. Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах, баяжуулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, засвар хийх, өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглахаар түр хугацаагаар оруулж ирсэн гадаадын барааг хугацаанд нь буцаан гаргаж барьцаалсан хөрөнгийг буцаан авах тохиолдолд мэдүүлэгч ашигласан бараа, материалын орцын норм, хэвийн хорогдлын хэмжээг тодорхойлон гаалийн байгууллагад өгнө. Гаалийн байгууллага орцын норм, хэвийн хорогдлын хэмжээг нягтлан шалгаж, буцаан гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүнд зарцуулагдсан материалд ногдох гаалийн болон бусад татварыг буцаан олгоно.

Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журмын 1 дүгээр хавсралт

БАРАА БАРЬЦААЛАХ ГЭРЭЭ

... оны ... сарын ... -ны өдөр

Мэдүүлэгч /зорчигч/: _____

Регистрийн №: _____ хаяг: _____

Гаалийн байгууллага: _____

Агуулах эзэмшигч: _____

Гэрчилгээ: _____ регистрийн №: _____ хаяг: _____ оны _____ сарын _____ ны өдөр хүртэл—хоногийн хугацаатайгаар энэ гэрээг байгуулав.

Мэдүүлэгчийн импортоор оруулж ирсэн бараа, түүнд ногдуулсан татвар:

Барааны нэр	Марк төрөл	Хэмжих нэгж	Тоо	Гаалийн үнэ	Ердийн тарифаар ногдуулсан татвар			Мэдүүлгийн	
					Үүнээс:		Бүгд	Дугаар	Огноо
					Гаалийн	НӨАТ			

Мэдүүлэгч нь дээрх бараанд ногдуулсан татварыг гэрээний хугацаанд бүрэн төлөх баталгаа болж ердийн тарифаар ногдуулсан татварын дүн

дээр түүний 10 хувийг нэмсэн дүнтэй дүйцэх хэмжээний дор дурдсан нэрийн барааг гаалийн үнээр тооцож барьцаанд үлдээн энэхүү гэрээг байгуулав.

Барааны нэр	Марк төрөл Онцлог шинж	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Гаалийн үнэ



Ногдуулсан татварыг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд гаалийн байгууллага барьцаанд байгаа барааг улсын орлогод шилжүүлэх хуудас бичиж борлуулан орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Хүлээлгэн өгсөн: _____	Барьцаалсан: _____
/мэдүүлэгч/	/гаалийн байгууллага/
Дарга: _____	Дарга: _____
Ня-бо: _____	Ня-бо: _____

Гаалийн улсын ахлах байцаагч _____

Гаалийн улсын байцаагч _____

Тэмдэг _____

Тэмдэг _____

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

_____ оны ... сарын ... -ны өдөр _____ гаалийн байгууллагын _____ банкны _____ тоот харилцах дансанд _____ оны _____ сарын _____ өдөр _____ төгрөг орсон тул _____ нэр төрлийн _____ төгрөгийн үнэ бүхий барааг мэдүүлэгчид буцааж олгов.

Барааг хүлээн авсан: _____	Барааг олгосон: _____
/мэдүүлэгч/	/гаалийн байгууллага/

Дарга: _____	Дарга: _____
Ня-бо: _____	Ня-бо: _____

Эд хариуцагч: _____ Гаалийн улсын ахлах байцаагч _____

Гаалийн улсын байцаагч _____

Тэмдэг _____

Тэмдэг _____

Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журмын 2 дугаар хавсралт

БАНКНЫ БАТАЛГАА

.....оны ... дугаар сарын -ны өдөр Дугаар Улаанбаатар хот

1. Төлбөрийн баталгаа гаргагч банкны нэр: _____
2. Банкны улсын бүртгэлийн регистрийн дугаар: _____
3. Банк байгуулах зөвшөөрөл олгосон: _____ № _____
(он, сар, өдөр) (дугаар)

Тус банк нь _____-д гаалийн байгууллагаас (мэдүүлэгчийн нэр, регистрийн дугаар)

_____нд (барааны нэр)

ногдуулсан гаалийн болон бусад татварыг төлөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мэдүүлэгчийн нэрийн өмнөөс _____

(тоогоор) _____ (үсгээр)

төгрөгийг гаалийн байгууллагад төлөх үүрэг хүлээж энэхүү төлбөрийн баталгааг гаргаж байна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үүргийг банк гүйцэтгэнэ.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг: _____

Албан тушаалын нэр: _____

Банкны тамга

Хаяг: _____



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм батлах тухай

Гаалийн тухай хуулийн 284.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын

22-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолын хавсралт

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь гаалийн улсын байцаагчийн дагаж мөрдөх сахилгын шаардлагыг тогтоож, түүнийг дагаж мөрдөх, биелэлтэд нь хяналт тавих, сахилгын зөрчил гаргасан гаалийн улсын байцаагчид шийтгэл ногдуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гаалийн улсын байцаагчийн сахилгын үндсэн зарчим

2.1. Гаалийн улсын байцаагч сахилгын дараахь үндсэн зарчмыг баримтлан ажиллана:

- 2.1.1. хуулиар хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
- 2.1.2. хуулиар олгогдсон эрхийг үл хэтрүүлэх;
- 2.1.3. хууль тогтоомжор хориглоосон үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байх;
- 2.1.4. гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчихгүй байх.

Гурав. Гаалийн улсын байцаагчийн сахилгын шаардлага

3.1. Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай, Гаалийн тухай хуулиар тогтоосон нийтлэг үүргээс гадна дараахь сахилгын шаардлагыг сахин биелүүлнэ:

- 3.1.1. албан тушаалын бүрэн эрхээ хуулийн дагуу хэрэгжүүлж, хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;
- 3.1.2. албан хэрэг хөтлөлт, санхүүгийн үйл ажиллагааны стандартыг чанд мөрдөх;
- 3.1.3. хувийн ашиг сонирхолдоо албан тушаалаа үл ашиглах;
- 3.1.4. албан ажлын холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулахгүй байх;
- 3.1.5. удирдлагын зүгээс шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр хүндрэл учруулж, цаг алдуулахгүй байх;
- 3.1.6. албан ажлын хэрэгцэний мэдээ, мэдээллийг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх.

Дөрөв. Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

- 4.1. Гаалийн улсын байцаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 4.1.1. татвар, хураамж болон гаалийн зөрчилд ногдуулах шийтгэлийг хөнгөрүүлэх, нуун дарагдуулах, хөнгөлөлт, туслалцаа үзүүлэх;
 - 4.1.2. бусдад хууль бус үүрг, даалгавар өгөх, хүсэлт гаргах, гүйцэтгэхийг шаардах;

4.1.3. албан тушаалын бүрэн эрхээ хувийн ашиг хонжоо олоход ашиглах, бусдад давуу байдал олгох;

4.1.4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилогдсон ажилдаа очихгүй байх, сэлгэн ажиллуулах гэрээ зөрчих, ажил таслах, ажлын байраа зөвшөөрөлгүй орхих;

4.1.5. хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх;

4.1.6. ажлын байранд, албан үүргээ гүйцэтгэх болон дүрэмт хувцастай үедээ сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа хэрэглэх;

4.1.7. гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ хайнга хандах, эсхүл дутуу хийж татвараас зайлсхийх, бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх боломж олгох;

4.1.8. хариуцах ажлын хүрээний болон гаалийн хяналт, бүрдүүлэлт, санхүүгийн үйл ажиллагаанд хөтөлгөд баримт бичгийг гаалийн бус зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах, үрэгдүүлэх;

4.1.9. гаалийн хяналт, шалгалтын арга тактик, албан хэрэгцээнд ашигладаг тоног төхөөрөмжийн талаархи мэдээллийг бусдад өгөх.

Тав. Гаалийн улсын байцаагчийн сахилгад тавих хяналт

5.1. Гаалийн удирдах албан тушаалтан нь өөрийн хариуцсан нэгжид ажилладаг гаалийн улсын байцаагчийн одор тутмын үйл ажиллагаанд сахилгын хяналт тавина.

5.2. Гаалийн удирдах төв байгууллага нь гаалийн улсын байцаагчийн сахилгад хяналт тавих, үнэлгээ өгөх, зөрчил гаргасан эсэхийг шалгах тогтоох бүрэн эрх бүхий Сахилгын хороотой байна.

5.3. Сахилгын хорооны бүрэлдэхүүн, хуралдааны дэг, сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

Зургаа. Сахилгын шийтгэл ногдуулах

6.1. Энэхүү дүрмийн 2.1-д заасныг зөрчсөн гаалийн улсын байцаагчийн үйлдэл /эс үйлдэхүй/-д эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуулийн 26.1, Гаалийн тухай хуулийн 284.1-д заасан сахилгын шийтгэлийг аль нэгийг ногдуулна.

6.2. Зөрчил үйлдсэн нөхцөл, шинж байдал, учирсан болон учирч болзошгүй хор хохирол, үр

дагавар, анх болон давтан үйлдсэн зэргийг нь харгалзан зөрчил гаргасан гаалийн улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулна.

6.3. Дараахь тохиолдол нь сахилгын шийтгэлийг хүндрүүлэн авч үзэх нөхцөл болно:

6.3.1. нэг зөрчил хойр болон түүнээс дээш удаа гаргасан;

6.3.2. бүлэглэж үйлдсэн;

6.3.3. санаатайгаар үйлдсэн;

6.3.4. албан тушаалаа урвуулж

ашигласан;

6.3.5. сэтгэцэд нөлөөлөх бодис /эм/, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн;

6.3.6. сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаанд давтан үйлдсэн.

6.4. Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахгүй.

6.5. Гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах сахилгын шийтгэлийн хугацаа 1 жил хүртэл байна. Байцаагчийн эрхээ хасуулсан ажилтан сахилгын шийтгэлийн хугацаа дуусахад Төрийн албаны зөвлөлөөс баталсан Гаалийн улсын байцаагчийн албан тушаалд иргэний ороход мэргэшлийн шалгалт авах болзол журам"-ын дагуу сонгон шалгаруулалтад орно.

6.6. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн

бол сахилгын шийтгэл ногдуулахгүй. Төрийн эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалтаар илэрсэн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахад энэ хугацааг баримтлахгүй.

6.7. Гаалийн улсын байцаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

6.8. Гаалийн улсын байцаагчид гаалийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах нь гаалийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд эрүүгийн болон бусад харууцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.9. Гаалийн улсын байцаагчийн үйлдэл /эс үйлдэхүй/-д эрүүгийн болон захиргааны харууцлага ногдуулаагүй нь түүнд сахилгын шийтгэл ногдуулахгүй байх үндэслэл болохгүй.

Долоо. Бусад

7.1. Гаалийн албанаас халах, гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах сахилгын шийтгэл хүлээсэн этгээд нь хувийн дугаар бүхий тэмдэг, энгэрийн тэмдэг, үнэмлэх, тооцоот хуудас, дүрэмт хувцасны тооцоог ажлын 3 хоногт багтаан хийж дуусгана.

7.2. Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд чөлөө авсан тохиолдолд сахилгын шийтгэлийн хугацааг чөлөөний хугацаа дууссаны дараа үргэлжлүүлэн тооцно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн өрөнхийлөн захирагч нарт даалгав:

1. Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим үлгээнд (www.e-procurement.mn) цаг хугацаанд нь бүрэн тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байсугай.

2. Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байсугай.

3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон худалдан авах ажиллагааны чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж байсугай.

4. Харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах эрхэг хэрэглэхдээ хууль зөрчөж байгааг илтлэг дутагдлыг арилгаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босгон үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж байсугай.

5. Захиалагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах

зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	18.000	19.000	24.000
2	Ханх, Ульханмайхан	27.000	33.000	30.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	80.000	120.000	100.000

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
САНГИЙН САЙД
С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган ..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.40 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, П.Очирбат, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням / илтгэгч / нарын бүрэлдэхүүнтэй, Нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Одбаяр нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн их суудлын хуралдааныг хойшлуулах хүсэлтийг Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ахлагч Ч.Сайханбилэг 2009 оны 06 дугаар сарын 05-нд; Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндэдалай 2009 оны 06 дугаар сарын 08-нд; Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаан дээр тус тус гаргасны дагуу Цэцийн их суудлын хуралдааны бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд хуралдаж, Цэцийн их суудлын хуралдааныг үргэлжлүүлэх тухай 07 дугаар магадлал гаргаж уншиж сонгосны дараа Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Одбаяр нар хуралдаанд оролцохоос татгалзаж, хуралдааныг орхин гарав.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн

дүгнэлт гарган ..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Нямдорж Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна" гэж заасны "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараах зүйл заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг;

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хуралцан ирэнгээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар

асуудлыг шийдвэрлэнэ. ...” гэсэн зүйлийн "...олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасныг;

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...” гэж заасантай тус тус нийцэхгүй, зөрчиж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д зааснаар Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дөрвөн гишүүн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гаргаж чадахгүй бол тус асуудал Байнгын хорооны болон чуулганаар хэлэлцэх боломжгүй байхаар хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, дэд хорооны гишүүдээс Улсын Их Хурлын гишүүнийг түдгэлзүүлэх эсэх асуудлаар татгалзсан, түдгэлзсэн, зөвшөөрсөн зэрэг тохиолдолд санал нэгдэж дүгнэлт гаргаж боломжгүй болж байна.

Ийнхүү санал нэгдсэн дүгнэлтэд хүрч чадахгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалт хэрэгжих боломжгүй болж, улмаар Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх эрх зүйн үндэс бүрдэхгүй гацаанд орж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтад “...шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг илтдэг зөрчихд хүргэж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх талаар ямар нэгэн шийдвэр Улсын Их Хурлаас гаргах нөхцөлгүй болгож байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт “Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ”, мөн 24 дүгээр зүйлд Байнгын хорооны бүрэлдэхүүнд дор дурдсан дэд хороо байгуулж болох гэсэн нь дэд хороо нь Байнгын хорооны нэг хэсэг бууно бүрэлдэхүүн байхаар шууд хуульчлан зааж өгсөн байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсэгт “Дэд хороо асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6-д тунхагласан “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн заалттай нийцсэн.

Энэ утгаараа асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл, дэд хороо асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцнэ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д заасан “...санал нэгдсэн дүгнэлт гаргана...” гэсэн заалт нь асуудлыг олонхийн саналаар шийдэх боломжийг хааж тус дэд хорооны гишүүд санал нэгдэж дүгнэлт гаргахаар хуульчилсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан заалттай зөрчилдөж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсэгт “Дэд хороо асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана” гэж заасан нь мөн хуулийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь ... гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж, санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна” гэсэн заалттай зөрчилдсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэнтэй нийцэхгүй байна.

Энэ утгаараа хуулиар харьяалуулсан хэрэг маргааныг шийдвэрлэх журам, шийдвэр гаргах үйл явц нь Байнгын хороо, түүний бүрэлдэхүүнд байх дэд хороонд адилхан үйлчилнэ гэж ойлгодог.

Дэд хороо нь тэр дундаа Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь дурдсан хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 болон 24.12-т заасан заалтын аль алийг нь хэрэглэх боломж бүрдсэн. Ингэснээрээ хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж төрийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдахад саад үүсгэн тэр дундаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчихд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, төрийн эрх барих дэд байгууллага Улсын Их Хурал хууль дээдлэх зарчмыг баримтлан үйл ажиллагаагаа хэвийн явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 болон 24.12-т заасан заалтуудын зөрчил саад учруулж байна.

Дээрх тайлбар болон үндэслэлийг харгалзан үзэж Үндсэн хуулийн цэцээс дараахь дүгнэлтийг гаргуулахыг хүч байна. Үндэс:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “...санал нэгдсэн дүгнэлт гаргана...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг, мөн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгтэй тус тус нийцэхгүй, зөрчиж байгаа гэсэн дүгнэлтийг гаргаж өгнө үү” гэжээ.

Хойр. Монгол Улсын Их Хурлын даргын 2008 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 153 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатрын Үндсэн хуулийн цэцэгд 2008 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн тайлбартаа:

“...Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болох тухай:

1. Улсын Их Хурлын гишүүн бол нийт ард түмний төлөөлөл болон сонгогддог субъект. Өөрөөр

хэлбэл, ард түмнээс бүрэн эрх авсан элч байдаг. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална" хэмээн заасан.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо байгуулахаар, 24.3.4-т түүнийг хэрэгжүүлэх чиг үүргийг, 24.7-д үйл ажиллагаа, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө урьдчилан хэлэлцэж эцсийн шийдвэр бус, урьдчилсан санал, дүгнэлт гаргах журмыг тусгайлан хуульчилсан заасан нь Үндсэн хуулиа дээдлэн, дээрх заалтыг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалсан явдал болно.

2. Хууль тогтоох үйл ажиллагаанд зарим тухайлсан онцлог харилцааг тусгайлан хэм хэмжээ тогтоон зохицуулах явдал байдаг. Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо санал нэгдсэн дүгнэлт гаргах тухай заалт нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын тухай асуудлыг шийдвэрлэхэд тусгай журам тогтоосон хэм хэмжээ болно.

3. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчим нь аливаа асуудал түүний дотор хуулиар зохицуулж буй нийгмийн харилцаа нь өөр өөрийн мөн чанар, онцлогоос шалтгаалан ялгаатай зохицуулалттай байхыг үгүйсгэсэн зарчим биш.

Иймд хуулиар тусгайлан зохицуулж өрсөлдөөр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын тухайд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчмыг зөрчсөн бус харин хангаж өгч буй явдал болно.

Хоёр, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн "олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ" гэснийг зөрчсөн гэх хууль зүйн үндэслэлийг болох тухай:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь дөрвөн гишүүнээс бүрдэхээр заагаад "санал нэгдсэн дүгнэлт гарган" гэсэн нь Үндсэн хуулиар хамгаалагдсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын эрх зүйн баталгааг хангахад чиглэгдсэн.

Мөн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар заавал хэлэлцдэг журмыг хуулиар тогтоосон. Эдгээр Байнгын хороод санал, дүгнэлтээ "олонхийн саналаар" гаргах бөгөөд Улсын Их Хурал / нэгдсэн хуралдаанаар/ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбоотой шийдвэрийг Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар "олонхийн саналаар" гаргана. Иймд Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй болно.

Гурав, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..." гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг болох тухай:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны эрх хэмжээг "... гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар... эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна" гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдож, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан санал ирүүлсэн тохиолдолд уг асуудлыг Улсын Их Хурлын чуулган хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, бэлтгэл шатны үйл ажиллагааг хуульчлан тодорхойлсон болно.

Хуулийн энэ заалтад Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хориголох, саад учруулах ямар нэг ойлголт байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо "... санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн заалт нь уг дэд хорооны гишүүд санал нэгдэж дүгнэлт гаргах үүрэгтэй болохыг тодорхойлноос бус "санал нэгдэхгүй" гээд дүгнэлт гаргахгүй байж болох тухай заагаагүй" гэжээ.

Гурав. Иргэн Д.Нямдоржийн 2008 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын хуулийн цэгцэд дахин нэмэгдүүлсэн шаардлага ирүүлсэн байна. Үүнд:

"...1. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... ардчилсан ёс, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг,

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дахь хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж заасантай тус тус нийцэхгүй, зөрчиж байна.

Монгол Улс нь олон улсын түвшинд Ардчилсан ёс тогтсон хэмээн хүлээн зөвшөөрөгдөөд багагүй хугацаа өнгөрсөн. Энэ нь олон шалгуур үзүүлэлтээр батлагддаг. Түүнчлэн Монгол Улс нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон талаар даяар олноо зарлан тунхагласан.

Энэхүү Ардчилсан ёсны үнэт зүйл гол занчлага нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх явдал юм.

Ардчиллын үнэт зүйлийг олон хууль тогтоомжид тусган Монгол Улсад ямарваа асуудлыг олонхийн саналаар шийдвэр гаргах үйл явц нэгэнт хэвшил болон тогтсон билээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д заасан "... санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн заалт нь асуудлыг олонхийн саналаар шийдэх боломжийг хааж тус дэд хорооны гишүүд санал нэгдэж дүгнэлт гаргахаар хуульчилсан нь ардчилсан ёсны зарчмыг алдагдуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан заалттай зөрчилдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хамгаалж "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх

эсхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж зөвхөн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалтай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулахыг тусгайлан заасан.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь ... гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж, санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Энэ утгаараа Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсхийг шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхээс бусад тохиолдол энгийн журмаар буюу Монгол Улсад хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд тулгуурлан явагдана гэж ойлгодог.

Тайлбар болон үндэслэлийг харгалзан үзэж Үндсэн хуулийн цэцгээс дараахь дүгнэлтийг нэмж гаргуулахыг хүсч байна. Үүнд:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт, Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалттай тус тус нийцэхгүй, зөрчиж байгаа гэсэн дүгнэлтийг гаргаж өгнө үү” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц энэхүү маргааныг 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцээд 10 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийг тогтоох хэсэгт:

“1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Арчигсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”; мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналар асуудлыг шийдвэрлэнэ. ...”; Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсхийг шийдвэрлэнэ. ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32

дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хууль авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай” гэсэн байна.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 1/106 тоот илбан бичгийн харууд Монгол Улсын Их Хурлын Жаргын 2009 оны 5 дугаар сарын 28-ний өдрийн 89 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн тайлбартаа:

“...Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаар Цэцийн дүгнэлтийг Хууль зүйн байнгын болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанд оруулдаг. Нэгдсэн хуралдаан Цэцийн дүгнэлт, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи Цэцийн дүгнэлтийг дэмжсэн бол түүнийг хүлээн зөвшөөрөх тухай, дэмжээгүй бол эс зөвшөөрөх тухай тогтоол баталдаг журамтай. Үүний дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны 2009 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цэцийн 2008 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлсэн. Байнгын хорооны хуралдаан дээр Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан нэрэмж бүлгээс Улсын Их Хурлын тухай хуулийн Булгийн эрх үйрэг гэсэн 27 дугаар зүйлийн 27.1.4-т “нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах” гэж заасны дагуу албан ёсоор завсарлага авсан болно. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2009 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны хэлэлцэх асуудалд дахин төлөвлөгдсөн боловч тухайн асуудлын талаар намхын Бүлгээс авсан завсарлага үргэлжилж байгаа тул хойшлуулсан. Хууль зүйн байнгын хорооны хуралдаан мөн үндэслэлээр хойшлогдож өдий хүрсэн болно.

Улсын Их Хурлын тухай хуулийн 29.9-д “...нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зохих байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана” гэж заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гарсны дараа асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Энэ бүхнээс үзвэл Улсын Их Хурал уг асуудлыг “санаатайгаар” хойшлуулсан гэх үндэслэл байхгүй болно.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын гаргасан тогтоолын үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг хэвнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй



болгож тогтоол гаргана. Цэцийн энэхүү эцсийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль Цэцийн тогтоол гармагц хүчингүй болдог. Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаараа Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргаагүй байхад Цэц их суудлын хуралдаанаараа маргааныг дахин хэлэлцэх үндэслэлгүй болно. Өмнө нь Цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 2008 оны 12 дугаар сарын 05-ны өдөр тайлбараа хүргүүлсэн болно” гэжээ.

Зургаа. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор ... шийдвэрлэнэ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т “Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана” гэж заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Их Хуралд удаа дараа албан бичиг явуулан хуулийн дагуу уг асуудлыг хэлэлцэн хариу ирүүлэхийг сануулсан. Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийн талаар тодорхой шийдвэр гаргалгүй 6 сар орчим хугацаа өнгөрсөн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, мөн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг болон дээр дурьдсан хуулийн заалтууд зөрчигдөхөд хүрсэн тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг хийжээр шийдвэрлэсэн болно.

ҮНДСЭЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Арчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"; мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"; мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ..."; Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь

түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар дүгнэлт нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 4, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ мөн хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна" гэж заасны "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Арчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"; мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"; мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ..."; Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэснийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

**Н.ЖАНЦАН
П.ОЧИРБАТ
Ж.БОЛДБААТАР
Ж.АМАРСАНАА
Д.НАРАНЧИМЭГ
Ц.САРАНТУЯА
Д.МӨНХГЭРЭЛ
Б.ПҮРЭВНЯМ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12

Төрийн ордон-128 тоот

и-мэйл: turin_medeel@parliament.mn



262420, 329612

Индекс 14003



329487

Хэвлэлийн хуудас 1.5